

## Номын сангийн тухай...

Бичсэн Enkhchimeg

2011 оны 4-р сарын 28, Пүрэв гариг, 00:32 - Сvvлд шинэчлэгдсэн 2011 оны 4-р сарын 28, Пүрэв гариг, 02:19

---

Номын сан- **Грекээс гаралтай vг** (biblioghkh-biblion <<ном>> ба qhkh <<хадгаламжийн газар >>). Номын сан гэж хувь хvн болон хуулийн этгээдэд тvр хугацаагаар ашиглуулах зорилгоор баримт бичгийн бvх торлоос гар бичмэл, ном, тогтмол хэвлэл, микрофильм, микрофиш, аудио болон видео материалууд, CD-ROM, DVD-ROM ба бусад бvрдvвлж зохион байгуулсан сан хомрог бvхий мэдээлэл, соёл, боловсролын вйлчилгээ vзvвлэгч байгууллагыг хэлнэ. Дэлхийн анхны номын санг Эртний Дорно дахинд vссэн гэж vздэг. Ихэнх эрдэмтэд ойролцоогоор м.э.о. 2500 жилд хамаарагдах Ниппур хотын Вавилоны сvмээс олдсон олон тооны шавран хавтан бvхий бичээсvвд гарсныг анхны номын сан гэж vздэг байна. Аливаа улсын номын сангийн тvvx нь тухайн улсад бичиг vсэг бий болсонтой холбоотой байдаг. Монголчууд бvр эртний Хvнv нар кэмv, дараа нь кидан, руни зэрэг бичгээр бичиж байсны дурсгал хадны бичиг хошоо чулуунд оноог хvртэл хадгалагдаж иржээ. Х зуунаас хойш уйгаржин бичиг хэрэглэх болж XIII зуунд торийн хэргээ энэхvв бичгээрээ хотолж, мон Чингисийн эзэнт улсын тvvxэн дурсгал "Монголын нууц товчоо", "Алтан дэвтэр" зэрэг олон тооны тvvx, уран зохиолын дурсгалт бичгийг бvтээжээ. Монголчууд номыг хус модны вйс, даавуун дээр утсаар шаглаж оёх, алт, монго, зэс зэрэг 9 эрдэнээр урлах зэргээр хийхээс гадна модон болон тугалган барын номыг сvвлийн гурав, дорвон зууны хугацаанд барлан тvгээж байжээ. "Манай дэлхийн хаана ч ном хэвлэдэг оньсон техник гараагvй байсан цагт Эртний Дорно дахинд, тvвний дотор Монголд бичсэн номоо хувилан олшруулах дот дохон нэгэн вйлдвэрийн арга боловсруулсан нь модон барын хэвлэл байлаа." гэж доктор Ц.Шvгэр тэмдэглэсэн байдаг. Ц.Шvгэр.Монгол модон барын ном.-УБ.:1991 Модон барын аргаар ном барлан олшруулах арга технологoо улам боловсронгуй болгон чулуун бар, хорголжин бар, томор барын аргаас ХХ зуунд орчин вейн аргаар ном хэвлэх аргатай золгосон байна.

"Монгол хvн зон нь тvvxийн урт удаан замыг туулахдаа тамга vсгээс эхлэн хятан, монгол, дорволжин, тод, соёмбо, манж, нангиад, ланз зэрэг vсгvвдийг хэрэглэж бичиг номоо тэмдэглэн ирсний дотроос товд, уйгаржин монгол, крилл монголоор хамгийн олон ном хэвлэсэн тvvxтэй" гэж доктор Ж.Цэзэн бvтээлдээ дурджээ. Ж.Цэзэн. Монгол ном.-УБ.:1999

Нэгэнт ном бий болсон учир ном хуримтлагдан хадгалах газар номын сан байгуулагдаж эхэлсэн байна. Монголчууд Британийн музейн номын сан, Америкийн Конгрессын номын сан байгуулагдахаас олон зууны омно XVII зууны дундуур дэлхийн анхны номын сангуудыг байгуулж байсан мэдээ байна.

Тvрэг улсын Истанбул хотноо 1995 онд хуралдсан Олон улсын номын санчдын холбооны 61-р еронхий бага хуралд Тvрэг улсын Үндэсний номын сангийн Еронхийлогч

## Номын сангийн тухай...

Бичсэн Enkhchimeg

2011 оны 4-р сарын 28, Пүрэв гариг, 00:32 - Сvvлд шинэчлэгдсэн 2011 оны 4-р сарын 28, Пүрэв гариг, 02:19

---

тавьсан илтгэлдээ "Марио Доссоны бичсэн "Монголын тvvх"-нд монголчууд торийн номын сангуудыг нийтэд зориулан Уйгарын хотуудад нээж байгуулсан тухай дурдсан байдаг. Караходжа дахь номын сангаас 30 мянган хуйлаас бичиг эрхбиш vлдэж хоцорчээ." хэмээгээд "Монголын эзэнт улсын хаан Хулагу 400 мянган боть бvхий номын санг Ираны Мерагийн Насереддино багшид зориулж байгуулахдаа Тов Азиар дамжин довтлох вeдээ Багдад Дамаскаас болон Элизираас авч бvрдvүлсэн номоо ашигласан байна" гэж Монголчууд XIII зууны эхээр номын сан байгуулж байсан баримтыг Ираны жишээгээр дурдсан байна. Монголчууд XIII зууны вeийн байлдан дагуулалтаараа соёлын овийг сvйтгэж балмад ажиллагаа явуулж байсан гэсэн Орнодийн ороосгол ойлголтыг дээр дурдсан мэдээлэл няцааж огсноор барахгvй торийн номын сангуудыг нийтэд зориулан монголчууд нээж байсныг гэрчлэх баримт болсон юм. Н.Цагаач. Эрдмийн сувд.-УБ.:2008

Монголчууд ийнхvv торийн номын сангуудтай байсны гадна нvvдлийн аж ахуйд тохирсон гэрийн номын сантай айлууд их байсан байна. Хуучны монголын айл орх бvрийн гол авдар дээр наад зах нь гурваас таван ном тавиастай байдаг байсан. Чинээлэгхэн монгол хvн, бичиг эрдмийн хvмvvс гэрийн номын сантай, тvvнээ vр хvvхэддээ вe залгамжлуулан омчлvvлдэг байжээ. Сэцэн хан аймгийн Үйзэн вангийн хошууны бичээч Тvмэнбаяр, мон аймгийн малчин ард Галсанпунцагийн Гочоо, Сайн ноён хан аймгийн Сэцэн чин вангийн хошууны бичээч Бэгз, мон аймгийн Чин сvжигт номун хан хутагт гэж алдаршсан Жамъянгаравын Цэдэнбалжир нарын зэрэг хувьдаа монгол, товд, самгарди, манж хэлний олон ном судар, тvvх, уран зохиол, гvн ухааны дурсгалт бичгийн цуглуулгатай хvмvvс олон байсан мэдээ байдаг.

Дархан чин ван Пунцагцэрэн хувийн номын сангаасаа монгол, манж, хятад бичгийн 2000-д номыг 1925 онд Судар бичгийн хvрээлэн Улсын Тов номын сан -д оргон барьж байжээ.

Монголчуудын номын сангийн ов нь гол толов сvм хийдvvдэд товлорч байжээ. Ялангуяа XVI зууны сvүлч XVII зуунд Бурхны шашин хvчтэй дэлгэрч эхэлсэнээс хойш сvм хийдvvд байгуулагдаж тэдгээрт ном судар олноор хуримтлагдан номын сангуудтай болсон байна. Сvм хийдийн номын сангуудын дотор Халхын найман богдоос уламжлан ирсэн XIX зууны сvүлч XX зууны эхэн вeийн Монголын шашин торийг хослон баригч Богд Жавзандамбын (1869-1924) номын сан байсан богоод монгол, манж, товд, самгарди зэрэг олон хэлний номноос "Энх-Амгалангийн бодлогын бичиг" (48 дэвтэр), "Хvйтэн уулын бичиг" (16 дэвтэр), "Хааны бичсэн Манж-Монгол vгийн тайлбар толь бичиг" (40 дэвтэр), "Жин-пин-мэй" бичиг (40 дэвтэр) зэрэг нь одоо Монголын Үндэсний номын сангийн ховор внэт номын фондонд хадгалагдаж байна. XX зуунтай Монгол орон золгохдоо гэрийн болон сvм хийдийн 800 гаруй номын сантай байсан байна.

## Номын сангийн тухай...

Бичсэн Enkhchimeg

2011 оны 4-р сарын 28, Пүрэв гариг, 00:32 - Сvvлд шинэчлэгдсэн 2011 оны 4-р сарын 28, Пүрэв гариг, 02:19

---

XX зууны Монголын номын сангийн хөгжил нь 1921 оны ардын хувьсгалын ялалттай нягт холбоотой юм. Ардын хувьсгал ялсанаас хойш дорвон сарын дараа нийт ард түмэнд үйлчлэх улсын анхны номын сангийн үндэс суурь тавигдаж 1921 оны 11-р сарын 9-нд Ардын засгийн газрын 24-р хурлын тогтоолоор Судар бичгийн хүрээлэн байгуулахаар зааж, Судар бичгийн хүрээлэнг Козины байрлаж байсан ондор байшинд байрлуулах, хүрээлэнгийн албан хэрэгцээнд зориулан 3000 лан монго олгохоор тогтжээ. Энэхүү хүрээлэнгийн дэргэд О.Жамъян, Ч.Бат-Очир, Д.Дашням, эрдэмтэн Цэвээн Жамсранов нар хувийнхаа номыг нийлүүлэн 2000 номоор анхны номын санг байгуулсан нь одоогийн Монгол Улсын Үндэсний номын сангийн эх үүсвэр болсон байна. Одоо Үндэсний номын сан нь 3 сая гаруй номын фондтой манай улсын тэргүүлэгч номын сан болон үйл ажиллагаагаа явуулж байна.

Оноодрийн байдлаар манай улсад нийт 1500 гаруй номын сан үйл ажиллагаагаа явуулж байна.

### Дэлхийн хамгийн алдартай номын сангууд

- Ассирын нийслэл Ниневи дэх Ашшурбанипал хааны номын сан
- Египетийн эртний Эллиний Александрийн номын сан
- Пергамийн номын сан
- Отрарийн номын сан
- Кордовын II Аль Хакакийн номын сан
- Ватиканы номын сан
- Париж дахь Францын Үндэсний номын сан
- Бээжин хот дахь Хятадын Үндэсний номын сан
- Милан дахь Амборзоны номын сан
- Флоренцийн Лауренцийн номын сан
- Вашингтоны Конгрессын номын сан
- Лондоны Британийн номын сан дэлхийн хамгийн их цуглуулгатай номын сан.

Оноодрийн байдлаар 150 сая гаруй нэгж ном, хэвлэлийн бүтээгдэхүүнтэй

- Оксфордын их сургуулийн Бодлейн номны сан дэлхийн эртний нийтийн номын сангуудын нэг

- Кембриджийн их сургуулийн номын сан
- Копенгагкийн Хатан хааны номын сан
- Берлиний Үндэсний номын сан
- Санкт-Петербургийн Оросын Үндэсний номын сан
- Баруун Европ дахь хувийн түүхэн цуглуулгууд: Валлендортийн номын сан,

Запускийн номын сан

- Швейцарь дахь ариун Галлийн сүмийн номын сан
- Прагийн Гейдельбергийн их сургуулийн дэргэдэх Палатины номын сан зэрэг ордог байна.

## Номын сангийн тухай...

Бичсэн Enkhchimeg

2011 оны 4-р сарын 28, Пүрэв гариг, 00:32 - Сvvлд шинэчлэгдсэн 2011 оны 4-р сарын 28, Пүрэв гариг, 02:19

---

Бэлтгэсэн Д.Оюунбилэг.